БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 26 өдөр Дугаар А/228 Улаанбаатар хот

Нийслэлийн 387 жилийн ойг
Тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10, 7 дугаар зүйлийн 7.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 387 жилийн ойг дүүрэгт тэмдэглэн өнгөрүүлэх ажил арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

2.Зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 2,730,000 (Хоёр сая долоон зуун гучин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил захирамж

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
А/228 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 387 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулагдах төсөв (сая.төг)	Хугацаа	Хариуцах байгууллага
2026 оны 10 дугаар сарын 28-ны өдөр				
1	“16 настай иргэний андгай өргөх” ёслолын арга хэмжээ зохион байгуулах, нийслэлд оролцуулах	2,5	11:00 цаг	ЗДТГ УБХэлтэс ХГБХХХ Соёлын ордон Боловсролын байгууллагууд
2	“Монгол хүний эрдэм” сургалт зохион байгуулах	1,0	12:00 цаг	ЗДТГ
3	“Багахангайн түүх” зургийн үзэсгэлэн зохион байгуулах	0.5	11:00-16:00 цаг	Архивын хэлтэс Соёлын ордон
4	Open mic зохион байгуулах /хүүхэд, насанд хүрэгч/	1,2	15.00 цаг	Соёлын ордон
5	“Багахангайн sale” арга хэмжээг дүүрэгт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа байгууллагуудад уриалах, зохион байгуулах	-	15:00-16:00 цаг	ХСТНААХ ЖДҮҮДТ
6	“Хүндэтгэл бахархал” арга хэмжээ зохион байгуулах	5,0	16:00 цаг	ЗДТГ
7	“Нийслэлийн өдөр”-ийг угтан зохион байгуулсан арга хэмжээний талаар орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах	-	Тухай бүр	ЗДТГ

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дугаар сарын 06 ны өдрийн
А/228 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛ ХОТ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 387 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
“Монгол хүний эрдэм” сургалт					
1	Сургагч багшийн хөлс	хүн	1	1,000,000	1,000,000
“Open mic” /хүүхэд, насанд хүрэгч/					
2	Тэргүүн байр	ш	2	100,000	200,000
3	Дэд байр	ш	2	80,000	160,000
4	Гутгаар байр	ш	2	60,000	120,000
5	Медаль	ш	6	45,000	270,000
6	Өргөмжлөл	ш	6	80,000	480,000
“Багахангайн түүх” зургийн үзэсгэлэн					
5	Фото цаас /А3/	боодол	1	40,000	40,000
6	Өнгөт принтерийн хор	ш	12	15,000	180,000
7	Жааз /А3, А4/	ш	14	20,000	280,000
Нийт дүн					2.730,000